



“Гермес Центр” ХК-ийн ТУЗ-ийн
УЛААНБАТЫР хот
2024 оны 08-р сарын 30-ны өдрийн
хурлын 13 тоот тогтоолын хавсралт

ГЕРМЕС ЦЕНТР
ХК

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТУЗ, ТҮҮНИЙ ДЭРГЭДЭХ ХОРООД, ТУЗ-ИЙН ДАРГА,
ГИШҮҮД, ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ
ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Гермес Центр” ХК (цаашид “Компани” гэх)-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны үр ашигтай байдалд үнэлэлт өгөх, түүнийг дүгнэхтэй холбоотой бүхий л харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 ТУЗ-ийн гишүүдийн эрх тэгш, ил тод байдал, зохистой засаглалыг хэрэгжүүлэх, шударга ёсыг хангах, хараат бус байх, нууцлалыг чандлан хадгалах зарчмыг баримтална.
- 1.3 Энэ журам нь “Компанийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Үнэлгээний зорилго

- 2.1 “Гермес Центр” ХК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх үнэлгээг дараах зорилгоор явуулна.

Үүнд:

- ТУЗ-ийн гишүүдийн хувийн зан чанар болон түүний мэдлэг, мэргэжил, ажлын туршлага, дадлагажсан чадвар зэргийг үндэслэн компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг бүрдүүлэх
- ТУЗ-ийн гишүүдийн үр ашигтай ажиллах хөшүүргийг бий болгох
- ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг тогтоох ил тод механизмыг бий болгох
- ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг үнэн зөвөөр тогтоох
- ТУЗ-ийн үйл ажиллагаанд үр ашигтай технологи ашиглах, шинээр нэвтрүүлэх
- ТУЗ-ийн гишүүдийн шаардлагатай сургалтын чиглэлийг тогтоох
- Компанийн засаглалын практик ажиллагааны чанарыг дээшлүүлэх

- 2.2 Үнэлгээ явуулахад дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Үнэлгээг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд явуулж байх
- Үнэлгээнд бодит, цогц бөгөөд шударгаар хандаж байх
- Үнэлгээг өмнөх үнэлгээний дүнтэй харьцуулах боломжтой хийх
- Үнэлгэчийг нууцлах

Гурав. Үнэлгээ явуулах хугацаа, үнэлгээний үр дүнг танилцуулах

- 3.1 Үнэлгээний асуулга нь дараах төрлүүдээс бүрдэнэ. Үүнд:

- ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх ерөнхий үнэлгээ
- ТУЗ-ийн даргын ажлыг үнэлэх үнэлгээ
- ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажлыг үнэлэх үнэлгээ
- ТУЗ-ийн хороодын даргын ажлыг үнэлэх үнэлгээ
- ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлыг үнэлэх үнэлгээ

- 3.2 Дээрх үнэлгээг үнэлгээний төрлөөс хамаарч дараах хугацаанд явуулна. Үүнд:

- ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх өрөнхий үнэлгээг жилд нэг удаа буюу дараа жилийн 2-р сард багтаан ТУЗ-ийн даргын удирдлага дор явуулж, үр дүнг ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна.
- ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх хороод, ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлыг жилд нэг удаа буюу дараа жилийн 2-р сард багтаан ТУЗ-өөс томилсон үнэлгээний комисс явуулж үр дүнг ТУЗ-ийн хуралд танилцуулахаас гадна гишүүн бүрийн үнэлгээг өөрт нь өгнө.

Дөрөв. Үнэлгээ явуулах

- 4.1 Үнэлгээ явуулах шийдвэрийг ТУЗ-өөс гаргана. Шийдвэрт үнэлгээ явуулах хугацааг тогтоох, үнэлгээний үйл ажиллагааг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг томилох, үнэлгээний асуулга бүхий хүснэгт зэргийг батална.
- 4.2 Үнэлгээ хийх асуулга бүхий загвар хүснэгтийг ашиглан явуулна. Энэхүү хүснэгтийн агуулга болон асуулга нь тухайн жилийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч өөрчлөгдөж болно. Үүнд:
 - ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх өрөнхий үнэлгээг хавсралт - 1
 - ТУЗ-ийн даргын ажлыг үнэлэх үнэлгээг хавсралт - 2
 - ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажлыг үнэлэх үнэлгээг хавсралт - 3
 - ТУЗ-ийн хороодын даргын ажлыг үнэлэх үнэлгээг хавсралт - 4
 - ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлыг үнэлэх үнэлгээг хавсралт – 5-аар батална.
- 4.3 Үнэлгээний хүснэгтийн дагуу үнэлгээ өгөх этгээд нь компанийн ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлага, түүний гишүүд байна.
- 4.4 ТУЗ нь үнэлгээний үр дүнд үндэслэн дараах чиглэлээр шийдвэр гаргана. Үүнд:
 - ТУЗ болон хороодын ажлыг сайжруулах талаар хийх ажлын төлөвлөгөө гаргах
 - ТУЗ-ийн гишүүдийн гишүүнийхээ үүргийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, зөвлөмжийг боловсруулах
 - ТУЗ-ийн гишүүдэд шаардлагатай мэдээлэл, нэмэлт мэдээлэл сургалт шаардлагатай эсэх
 - ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын асуудал
 - ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүн, ТУЗ-ийн гишүүнд улируулан нэр дэвшүүлэх эсэх.
- 4.5 Компанийн ТУЗ нь үнэлгээний үр дүнгийн талаарх тайлан мэдээ, түүнтэй холбогдуулан гаргасан тогтоол шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна.

Тав. Үнэлэх шалгуур үзүүлэлт, үнэлгээний дүгнэлт гаргах

- 5.1 Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааг доор шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан хавсралт – 1-д үзүүлсэн хүснэгт дэх асуулгад энэхүү журмын 4.3-т заасан этгээдүүдээс өгсөн үнэлгээг үндэслэн дүгнэлт өгнө.
 - ТУЗ-ийн ажлын баримт бичгийн бүрдэл
 - ТУЗ-ийн ажиллах журам, мэдээллийн хангалт
 - ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн
 - ТУЗ-ийн эрх, үүргийн хэрэгжилт
 - ТУЗ-ийн даргын эрх үүргийн хэрэгжилт
 - Хороодын үйл ажиллагаа
 - ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын харилцаа
 - ТУЗ-ийн гишүүдийн эрх, үүргийн хэрэгжилт

5.2 ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлыг доорх шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан хавсралт 5-т үзүүлсэн хүснэгт дэх асуулгад энэхүү журмын 4.3-т заасан этгээдүүдээс өгсөн үнэлгээг үндэслэн дүгнэлт өгнө. Үүнд:

- Ажлын туршлага
- Эзэмссэн мэргэжил, түүнийгээ эзэмшсэн байдал, дадлагажилт
- Салбарын мэдлэг, биенес явуулах чадвар
- Ажил хэрэгч байдал
- Алсын хараа, стратегич байдал
- Үнэнч шударга байдал
- Хуралд оролцох оролцоо
- Хуралд өөрийгөө бэлтгэсэн байдал
- Багаар ажиллах чадвар
- ТУЗ-ийн үйл ажиллагаанд оруулах хувь нэмэр
- ТУЗ-ийн гишүүний эрх үүргийг хэрэгжүүлдэг байдал

5.3 Хороодын үйл ажиллагааг доорх шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан хавсралт 4-т үзүүлсэн хүснэгт дэх асуулгад энэхүү журмын 4.3-т заасан этгээдүүдээс өгсөн үнэлгээг үндэслэн дүгнэлт өгнө. Үүнд:

- Хороо нь өөрт олгосон эрхийн хэм хэмжээнд ажиллаж байгаа эсэх
- Хорооны гишүүд хорооны эрхлэх ажлын хүрээний мэдлэг, чадвартай эсэх
- Хорооны хурлын бэлтгэл зохих ёсоор хангагдаж хурал зохих журмын дагуу хийгдэж чаддаг эсэх
- Гишүүд гишүүнийхээ үүргийг хэрэгжүүлснийхээ төлөө урамшуулал авдаг эсэх
- Хороо нь ТУЗ-өөс хүлээж буй үр дүнг үзүүлдэг эсэх

5.4 Үнэлгээний нэгдсэн дүгнэлтийг энэ журмын 4.1-т заасны дагуу ТУЗ-ийн хурлаас томилогдсон комисс мөн журмын 4.4-т заасан асуудлаар ТУЗ-д дүгнэлт гаргана.

5.5 ТУЗ үнэлгээний комиссоос гаргасан дүгнэлтийг үндэслэн журмын 4.5-д заасан асуудлаар шийдвэр гаргана.

Зургаа. Бусад

6.1 Энэ журмыг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.

6.2 Энэхүү журмын хэрэгжилтийг жил бүр хэлэлцэж, зохих өөрчлөлтүүдийг оруулна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**РМЕСЦ
ХК**

ТТБ1437.27